



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Швейцарийн хөгжлийн агентлаг



Цөлжилтийг Сааруулах Төсөл
МОНГОЛ



“БУЯНТ ГОЛЫН УС АШИГЛАГЧДЫН ЗӨВЛӨГӨӨН”-ӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Ховд хот

2008 оны 3-р сарын 11-12

Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг (SDC)-ийн “Цөлжилтийг сааруулах төсөл”, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран “Буянт голын Ус ашиглагчдын зөвлөгөөн”-ийг 2008 оны 3-р сарын 11-12-ны өдрүүдэд Ховд аймгийн төвд зохион байгуулав.

Уг зөвлөгөөнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Усны хэрэг эрхлэх газар, Ус, цаг уурын хүрээлэн, Буянт голын сав дагуу оршдог Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум, Ховд аймгийн Дуут, Ховд, Буянт, Мянгад, Жаргалант сумын олон байгууллагын төлөөлөгчид хамрагдлаа. Нэг голын ай савын байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах асуудлыг өргөн хүрээнд тусгайлан авч хэлэлцэж байгаагаараа түүхэн ач холбогдол бүхий энэ удаагийн зөвлөгөөнд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, төрийн захиргаа, үйлчилгээ, хяналт, шалгалт, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллага, хувийн салбар, малчид, тариаланчид, төрийн бус байгууллагыг төлөөлсөн 140 гаруй төлөөлөгч оролцлоо. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тариаланчид, ногоочид, малчид зэрэг усыг хөдөө аж ахуйн зориулалтаар өргөн хэрэглэгдэг ус ашиглагчид оролцсон нь практик шийдэлд хүрэхэд үр дүнтэй боллоо.

Энэ арга хэмжээнд орон нутгийн хэвлэл, мэдээллийн албаны төлөөлөгчид өргөнөөр оролцож, уг зөвлөгөөний үйл ажиллагааны явц, ач холбогдол, түүнээс гаргасан санал, зөвлөмжийг ард иргэдэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэж байна.

Зөвлөгөөнд оролцогчид Буянт голын сав газрын усны нөөцийг зохистой ашиглах талаар хамтран ажиллах нэгдсэн ойголтод хүрлээ.

Ус ашиглагчид, нэн ялангуяа газар тариалан, хүнсний ногоо эрхэлдэг иргэд, байгууллагын болон бусад төлөөлөгчид “**усыг үнэ төлбөртэй**” болгох нь усны нөөцийн тогтвортой, зөв ашиглалтыг бий болгох гол хөшүүрэг гэдгийг санал болгосныг онцлон тэмдэглэж байна. Энэ нь хууль тогтоогчдын шийдэх асуудал болохыг сонордуулж байна.

Зөвлөгөөний төгсгөлд нийт оролцогчид “Ховд, Баян-Өлгий аймгийн нутгийн удирдлагын байгууллагын хүрээнд”, “Орон нутгийн ард иргэдийн хүрээнд”, “Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын хүрээнд (төрийн бус байгууллага, нөхөрлөл, холбоо гэх мэт)”, “Бусад талуудын хүрээнд (төсөл, хувийн салбар гэх мэт)” цаашид тавих зорилт, шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээг тусгасан дараах “**ЗӨВЛӨМЖ**”-ийг гаргалаа. Үүнд:

Ховд, Баян-Өлгий аймгийн нутгийн удирдлагын байгууллагын хүрээнд:

- Усны хуулийн дагуу Буянт голын Сав газрын зөвлөл байгуулах,

- Буянт голын савыг зохистой ашиглах, хамгаалах хөтөлбөр гаргах (сум бүр дэд хөтөлбөртэй байна),
- Усны хуулийн дагуу бүсүүдийг (онцгой хамгаалалтын, эрүүл ахуйн, энгийн хамгаалалтын) тогтоож, бүсийн дэглэмийг мөрдүүлэх,
- Буянт голын сав газрын байгалийн баялагийг байгаль орчны ерөнхий ба нарийвчилсан үнэлгээ хийлгүүлсний үндсэн дээр ашиглуулах,
- Буянт голын савын байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн болон иргэдийн хяналтын тогтолцоог сайжруулах,
- Буянт голын сав, ялангуяа эх орчмын газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалтанд оруулах боломжийг судлах, шийдвэрлэх,
- Буянт голын сав газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулан, нарийвчилсан катастрын зураглал хийж, хэрэгжилтийг хангах,
- Газар өмчлөх, эзэмших эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх,
- Буянт голын сав дагуу хийх ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг нэгдсэн төлөвлөлт, зураглалын дагуу жил бүр хийж байх,
- Хөв, цөөрөм, бага оврын усан сан байгуулах замаар цас, мөсний усны нөөцийн ашиглалтыг сайжруулах явдлыг урамшуулах, дэмжих,
- Буянт голын усны нөөц, ашиглалтын судалгаа, мониторингийн ажлыг тогтмолжуулж, үр дүнг ард иргэдэд хүргэх,
- Нэг ус ашиглагчийн хэрэглэх усны дээд хязгаарыг тогтоох (хоног, сар, жилээр),
- Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Голын сав газрын тодорхой хэсгийг зохих хууль, журмын дагуу байгаль хамгаалах нутгийн иргэдийн нөхөрлөлд гэрээгээр хариуцуулж, зохистой ашиглах бодлого баримтлах,
- Ус ашиглалтыг сайжруулахад чиглэсэн зарим үйл ажиллагааг байгаль орчны чиглэлийн иргэний нийгмийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх,
- Буянт голын дагуу атар газар шинээр эзэмшүүлэхгүй байх, харин атаршсан газрыг нөхөн сэргээх,
- Буянт голын сав газрын мэдээллийн санг бий болгож, мэдээлэл, сургалт, сурталчилгааг сайжруулах,
- Ховд хотын гүний болон гадаргын усны алдагдлыг бууруулах, цэвэр, бохир усны системийг сайжруулах,
- Цэвэрлэх байгууламжийн ажиллагаанд үнэлгээ хийж, стандартын түвшинд ажиллуулах,
- “Жанжин” боолтыг төсвийн санхүүжилттэй орон тооны хариуцах эзэнтэй болгож, усыг хуваарьтай ашиглах,

Орон нутгийн ард иргэдийн хүрээнд:

- Хоорондоо эвлэлдэн нэгдэж ус ашиглагчдын холбоо, нөхөрлөл, төрийн бус байгууллага байгуулж, усны асуудлаа шийдвэрлэхэд өөрсдөө санаачлагатай оролцдог болох,
- Ганд тэсвэртэй нутагшсан сортыг сонгон тариалах, сэлгээг зөв зохистой хэрэглэх, усыг хэмнэлттэй зарцуулдаг тариалангийн технологийг нэвтрүүлэх,
- Бэлчээрийн даацанд нийцсэн тоо, толгой, сүргийн бүтэц бүхий чанарлаг малтай болох,

- Байгалийн баялаг, бэлчээрийг зохистой ашиглах уламжлалт арга, ёс заншлыг сэргээх,
- Суваг, шуудууг доторлох замаар усны алдагдалыг багасгах,
- Хөв, цөөрөм, бага оврын усан сан байгуулах замаар цас, мөсний усны нөөцийн ашиглалтыг сайжруулах талаар санаачлагатай ажиллах,
- Түлшинд модлог, бутлаг ургамлыг хэрэглэхээс татгалзах, тэдгээрийн ашиглалт, хамгаалалд тавих хяналтын тогтолцоог бий болгох, орлуулах боломжит технологиудыг хэрэглэж занших,
- Нөхөн сэргээх арга хэмжээг жил бүр санаачлагаараа хийдэг болох,

Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын хүрээнд (төрийн бус байгууллага, нөхөрлөл, холбоо гэх мэт):

- Голын усны ашиглалт, бохирдолтод байнгын хяналт тавьдаг болох,
- Сав газрын зөвлөл, ус ашиглагчдын холбоо байгуулахад санаачлагч байх,
- Буянт голын сав, ялангуяа эх орчмын газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалтанд оруулах талаар санаачлага гаргаж ажиллах,
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Голын сав дагуу хийх ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажилд санаачлагатай оролцох,
- Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг цогц байдлаар зохион байгуулах,
- Голын сав газрын байгалийн баялагийг гэрээний дагуу хамтран зохистой ашиглах, эзэмшихэд санаачлага гаргах,
- “Буянт гол ”сан байгуулах ажлыг зохион байгуулах,

Бусад талуудын хүрээнд (төсөл, хувийн салбар гэх мэт):

- Буянт голтой холбоотой судалгааны баримт, мэдээлэл, усыг зохистой ашиглах уламжлалт болон дэвшилтэт арга, технологийг олон нийтэд хүргэх,
- Сав газрын зөвлөл байгуулах, түүнийг тогтвортой ажиллуулахад дэмжлэг үзүүлэх,
- Буянт голын сав газрыг зохистой ашиглах, хамгаалах хөтөлбөр, менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Сав газрын газар зохион байгуулалт, газар ашиглалтын төлөвлөгөө, зураглал хийхэд дэмжлэг үзүүлэх,
- Мэдлэг олгох, хандлага өөрчлөх сургалтууд зохион байгуулах,
- Хөв, цөөрөм, бага оврын усан сан байгуулах замаар цас, мөсний усны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх
- Дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Байгаль орчинд халгүй түлшний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих,
- Шаардлагатай жижиг төслүүдийг санхүүжүүлэх,
- Голын савыг, ялангуяа эх орчмын газар нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад оруулахад дэмжлэг үзүүлэх,